

Нүдэнд ил боловч “анзаардаггүй” аюултай химийн бодисууд

2020 оны 10-р сар

БЕЙРУТ ХОТОД ТОХИОЛДСОН ДЭЛБЭРЭЛТ



Google гудамж, 2017 оны 4-р сар



EPA, 2020, 08-р сарын 05

BBC

Лебанон улсын Бейрут хотод 2020 оны 08-р сарын 4-нд үүссэн дэлбэрэлтийн өмнөх болон дараах зураг

2020 оны 08-р сарын 04-ний өдөр Лебанон улсын Бейрут хотод маш том хэмжээний дэлбэрэлт үүсч 160 орчим хүн амиа алдаж, 5000 гаруй хүн гэмтэж, ойролцоогоор 300.000 хүн орон гэргүй болжээ.* Хохирлын хэмжээ болон дэлбэрэлтийн шалтгааныг одоогоор бүрэн тодорхойлоогүй байна. Тус дэлбэрсэн материалыг (аммиакийн шүү) бордоонд түгээмэл ашигладаг, мөн уурхайд тэсэлгээний бодис болгон ашигладаг аж. 6 жилийн турш ойролцоогоор 2750 тонн (3030 америк тонн) орчим материалыг агуулахад хадгалсан байжээ. Албаны ажилтнууд тухайн материалыг байгаа гэдгийг болон нийт хадгалагдсан хугацааг мэдэж байсан хэдий ч хадгалалтыг хянах тал дээр хангалттай арга хэмжээ аваагүй байсан. Бейрут хотод гарсан тус дэлбэрэлтийн дараа зарим боомтууд аммиакийн шүүний хадгалалтыг хязгаарлах болон зогсоох талаар тодорхой алхмуудыг хэрэгжүүлжээ. (Вашингтон Пост, 2020. 08.21)

Бид өдөр бүр олон зүйлийн дэргэдүүр явж өнгөрдөг бөгөөд удаан хугацаа өнгөрөх тусам анзаарч “харахгүй” болох тохиолдлууд байдаг. Энэ нь ердийн ажлын байрны эмх цэгцээс том зүйл юм. Бүх төрлийн химийн бодис, ялангуяа задардаг бодисуудын хувьд зөв хадгалалт маш чухал.

Танай ажлын талбайд тогтмол ашиглагддаггүй химийн бодисын сав, боошиг байдаг уу? Тэдгээрийн гадна шошгыг та уншиж байсан уу?

(* тус Beacon хэвлэгдэх үеийн статистикийн мэдээлэл)

Та мэдэх үү?

- Зарим химийн бодис хадгалалтын хугацаатай байдаг ба хэт удаан хадгалах эсвэл хадгалалтын нөхцөл буруу байх тохиолдолд задрах аюултай. Чийг, агаар болон бусад материалын нөлөөгөөр бодис задарч болзошгүй.
- Задралын улмаас:
 - бодисын хүч суларснаар материалын чанар алдагдах;
 - бэхжүүлэгч, урвал удаашруулагч зэрэг аюултай материалыг аюулгүй байлгах зориулалттай нэмэлт бодисуудад сөргөөр нөлөөлөх;
 - асар хүчтэй, гамшгийн түвшний эрсдэлтэй задрал үүсэх боломжтой.

(2006 оны 1-р сарын Beacon-ыг харна уу.)

(<https://www.aiche.org/ccps/resources/process-safety-beacon/archives/2006/january/english>)

- Хор Аюулын Лавлах (ХАЛ) баримт бичигт ихэвчлэн химийн бодистой хэрхэн харьцах, хэрхэн хаях талаарх мэдээлэл буюу зөв хадгалалтын нөхцөл болон бусад зааварчилгааг бичсэн байдаг.
- Тухайн талбайд ашиглагддаггүй химийн бодис хадгалснаар материал гоожих, асгарах эрсдэлтэй.
- Материалыг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлж хадгалах тусам болзошгүй асгаралт, гоожилтын хэмжээ нэмэгдэнэ гэсэн үг.

Та юу хийж болох вэ?

- Танай ажлын талбайд удаан хугацаанд хадгалагдаж буй химийн бодисын сав, боошиг байгаа эсэхийг шалга. Тэдгээрийн ашиглалтын хугацааг шалгаж, зөв хадгалалтын нөхцлийг нягтал.
- Хэрэв химийн бодисын саван дээрх ашиглалтын хугацаа хэтэрсэн байвал ахлах ажилтандаа даруй мэдэгд. Хуучин савыг нээж, зөөж болохгүй. Доторх материал нь хувирамтгай эсвэл савны дотор тал зэвэрсэн байж болзошгүй.
- Саван дээрх ашиглалтын хугацаа хэтрээгүй байсан ч тухайн хэсэгт хадгалж байгаа шалтгааныг нь тодруул. Магадгүй тэнд орхиод мартсан байж болно. Тийм бол зориулалтын хадгалах талбай руу зөөх хэрэгтэй..
- Аливаа материалыг ашиглахдаа үйлдвэрлэсэн хугацааг шалгаж, дуусах хугацаа хамгийн ойртсоныг нь эхэлж хэрэглэх нь зүйтэй. – ХУГАЦАА НЬ ДУУСААГҮЙ БАЙГАА ТОХИОЛДОЛД!

Материал удаан хугацаагаар хадгалагдахаас болгоомжил!